



**ЗАВХАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 10

Улиастай

ТАНИЛЦУУЛГА

Албаны 2022 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улиастай сумын Хүүхдийн 7-р цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 09 дүгээр удирдамжаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийв.

АУДИТЫН ЦАР ХҮРЭЭ

Аудит, санхүүгийн дотоод хяналт шалгалтын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Аудит, дотоод хяналт шалгалтын хамрах хүрээ

Тус цэцэрлэгийн 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, цалин хөлс олголт, байгууллага хоорондын тооцоо, худалдан авах ажиллагаа, санхүүгийн холбогдолтой хууль, эрх зүйн актуудын хэрэгжилт зэргийг хамруулсан.

Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно.

Аудит, санхүүгийн дотоо хяналт шалгалтын хугацаа

Аудит, санхүүгийн хяналт шалгалтыг 2022 оны 03 дүгээр сарын 21-ний өдрөөс 2022 оны 04 дугаар сарын 20-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Анх 1985 онд Өлзийт багийн нутаг дэвсгэрт хүүхдийн төлөө фондын хөрөнгөөр ясли цэцэрлэгийн комбинат нэртэй 90 хүүхдийн хүчин чадалтай 4 бүлэг, 5 багш, 15 ажилтантай байгуулагдаж, одоо 4 бүлэг 115 хүүхэд 21 багш ажилтантай 2-5 хүртэлх насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг эзэмшүүлэх үйл ажиллагаагаа явуулж байна.

2020-2021 онд удирдах ажилтан-1, гүйцэтгэх ажилтан-9, үйлчлэх ажилтан-11, нийт 21 ажиллагсадтай. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдийг эрүүл, тохилог орчинд, харилцааны зөв хандлага дадал хэвшилтэй, өөрийн онцлог чадвар, бүтээлч

үйлээр хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллах зорилтыг үйл ажиллагааны чиглэл болгон хичээл хүмүүжлийн ажлаа явуулж байна.

Байгууллагын засаглалын талаар

БШУГазар аймгийн хэмжээний соёлын болон сургууль цэцэрлэгийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг явуулахын тулд мэргэжил арга зүйгээр хангаж, удирдан чиглүүлэх үүрэгтэйгээр, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх үүрэгтэйгээр оролцдог.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Улиастай сумын ЗДТГ, Сумын ИТХ-ын тэргүүлэгчид үнэлэн, үр дүнгээр урамшуулан ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын талаар

Тус цэцэрлэг нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, тусдаа нэгж байгуулаагүй, дотоод хяналтын нэгж хариуцан ажиллаж байна.

Засаглах удирдлагаас стратеги, зорилго зорилтыг батлан гаргах боловч эрсдэлийг тодорхойлоход оролцдоггүй.

Дотоод хяналтын талаар

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн байгууллагын дотоод хяналтын зөвлөлийг эрхлэгчийн тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулан ажилласан байна.

Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллагын 2018, 2019 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд ДА-СХШУАБ Б.Батхүү, ДА-СХШУБ С.Пүрэвгарьд нар төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэж Мэнд Тэх ХХК-аас хүнсний материал авахдаа е-баримтгүй, татвар суутган тооцоогүй гүйлгээ хийсэн, шатахуун замын хуудасгүй, үндсэн баримтгүй зарцуулсан зэрэг 257,9 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлбөрийн акт тогтоосныг 100% барагдуулсан байна.

Тухайн байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Заяа баталгаажуулах аудитыг хийж зөрчилгүй дүгнэлт, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитор Г.Мөнхнасан баталгаажуулах аудитыг хийн “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн орлогын бүрдүүлэлт, орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

2020 онд нэгдүгээр гарын үсгийг эрхлэгч Ц.Шанд, 2021 онд Д.Цэгмид нар хөрөнгө захиран зарцуулах эрхийн нэгдүгээр гарын үсгийг зурж хөрөнгийг зарцуулсан.

2020, 2021 онд хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ш.Оюун-Эрдэнэ нар зурж хөрөнгийг зарцуулсан.

Д/д	Зардлын зүйл, анги	2020		2021	
		Гүйцэтгэл	Төсөвт эзлэх %	Гүйцэтгэл	Төсөвт эзлэх %
1	Цалин, НДШ	247717174	80.0	247803425	76,0
2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28738288	9.3	29855131	9.1
3	Хангамж, бараа материалын зардал	6204229	2.0	14111810	4.3

4	Материал, нормативт зардал	17612220	5.7	18061750	5.5
5	Бараа үйлчилгээний бусад зардал	782600	0.3	941700	0.3
6	Урсгал шилжүүлэг	2641500	0.8	391500	0.1
7	Бусдаар гүйцэтгүүлсэн	6175600	1.9	15550400	4.7
	Дүн	309871611	100	326715717	100

Өр авлагагүй ажилласан ололттой тал байна. Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.3-д заасан “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтын дагуу төсвийн хэрэгжилтийн талаархи үүргүүдийг биелүүлэн ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэл, анхан шатны маягт хөтлөлтийн талаар

Нярав тайлангаа цаг тухай бүр тогтмол гаргаж хэвшсэн байна. Энэ нь нягтлан бодогчийн тайлан зөв гаргахад шууд хамааралтай тул анхан шатны баримтуудаас харагдаж байна. Эд хариуцагч нь хүчин төгөлдөр баримтаар бараа материалыг орлогод авч, цаг тухайд нь бүртгэлд тусгах, хадгалалт хамгаалалт бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллаж байна. Эд хариуцагчийн гаргасан тайлангийн баримтын бүрдэл, хүчин төгөлдөр эсэхийг нягтлан бодогч шалгаж хүлээж авсан байна.

Хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, бүртгэл, хяналт

2020 онд 66 хоног хичээллэж 5820 хүүхдэд 14406,0 мянган төгрөг, 2021 онд 100 хоног хичээллэж 3602 хүүхдэд 8916,4 мянган төгрөгийн хоолны зардал гарсан. Аймгийн онцгой комисс болон БСУГ-ын даргын шийдвэрээр 2020 онд зорилтот бүлгийн 15 хүүхдэд 533,9 мянган төгрөгийн хоолны материал олгосон. 2021 онд өндөржүүлсэн бэлэн байдлын үед пост, штабт ажиллаж байсан 926 хүнд 2132,4 мянган төгрөгийн хоол, эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдэд хүнсний дэмжлэг үзүүлэх 1074,5 мянган төгрөг, 2020 онд вакцинжуулалтанд ажилласан багийн эмч, өндөржүүлсэн бэлэн байдлын үед постонд ажиллаж байсан 15 хүнд 213,4 мянган төгрөгийн хоол өгсөн байна /пост, вакцинжуулалтанд ажиллах, ажилласан хүмүүсийн тоо болон нэг хүнд ногдох хоолны зардлыг баталсан шийдвэр байхгүй/.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

2020 онд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 2021 онд 149 мэдээллээс 141 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулж 1 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ЗӨРЧЛИЙН ХУУЛИЙН ЗААЛТ

Эрхлэгчид эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл, урамшуулал олгосон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.3 “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана” заалтуудыг зөрчсөн байна.

Шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүй үндсэн баримтгүй зарцуулсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно”

Эд хариуцагчийн дансаар дамжуулан тээврийн хөлс олгосон, ажил гүйцэтгүүлэх гэрээгүй байгуулаагүй зориулалт бус зардал гаргасан /онц шаардлага гарсан тохиолдолд мөнгөн шилжүүлэгийн баримтаар баталгаажуулан цааш юунд зарцуулсанг тодорхойлох/ төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1” Төсвийг үр ашигтай хэмнэлттэй

байхаар төлөвлөж зарцуулах” , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”

Дээрх зөрчлүүдтэй холбоотой нийт 1518,7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төлүүлэхээр нөхөн төлбөрийн акт тогтоож ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, эрсдэлийн удирдлага хангалтгүй байгаа тул эрсдэлийн үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Үндсэн үйл ажиллагаанд дотоод хяналтын үр нөлөө бага, дотоод хяналт хангалтгүй дүгнэгдсэн нэр төдий байгаа тул дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Ес: Цаашид хийх ажлын талаарх зөвлөмж

1.Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэл, төсөл хөтөлбөр, хүүхдийн хоолны материал худалдан авахад гарч болох эрсдэлийн үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

2.Хүүхдийн хоолны материалыг тендерт шалгарсан газраас гэрээ байгуулан худалдан авдаг байх

3.Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу төсвийг зарцуулах

4.Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг санхүү, төсөл, хөтөлбөр, худалдан авалтын зардлуудад чиглүүлэн хяналт шалгалт хийж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах

5.Актын төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулж хураан барагдуулалтын тайланг ирүүлэх.

ТАЙЛАН БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДА-СХШУБ Т.ЦЭРЭНДОЛГОР

